АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1. Төслийн товч танилцуулга
1.2. Үйлдвэрийн барилга, байгууламж
1.3. Үйлдвэрийн танилцуулга
1.3.1. Шингэн хүнсний үйлдвэр
1.3.2. Хуурай хүнсний үйлдвэр
1.4 Үйлдвэрийн хүчин чадал, технологи, тоног төхөөрөмж
1.4.1 Хүчин чадал
1.4.2 Тоног төхөөрөмж
1.5 Бүтээгдэхүүний нэр төрөл
1.6 Чанарын хяналтын лабораторийн товч мэдээлэл
1.7 Дэд бүтэц
1.8 Хог хаягдал

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө
2.3 Тэрбум мод үндэсний хөтөлбөр
2.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
2.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
2.6 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
2.7 Байгаль орчин хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
2.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

## *1.1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА*

*Төслийн нэр:* Шингэн болон хуурай хүнсний үйлдвэрийн төслийн нэмэлт тодотгол

*Төслийн байршил:* Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Сонсголонгийн зам, 32/3 тоот, Утас: 77773525, Улсын бүртгэлийн дугаар 90100020005, Регистр дугаар 5568927

*Компанийн танилцуулга*: "Монос Хүнс" ХК нь Монос группын салбар компани бөгөөд хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр 2011 оноос үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний үйлдвэрлэгч компани юм. "Цэнэг" эрүүл мэндийн бэлдмэл, "Энхжин" цай, Аньс, нэрс, чацарганатай "Эко уусдаг цай", "Berry-Vit" ааруултай, үзэмтэй, витаминт төрөл бүрийн үрлүүд, Экос эрүүл мэндийн ус, Хаан жимс чацарганын цэвэр тос, аньс нэрс чацарганын шүүс зэрэг 82 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд худалдаалж байна. Тус компани ISO 9001:2015, HACCP стандартын шаардлагад нийцүүлэн чанарын менежментийн оготолцоог бий болгож, баримтлан хэрэгжүүлж, түүний үр нөлөөг байнга сайжруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласнаар олон улсын SGS байгууллагаас 2019 онд стандартын гэрчилгээгээ гардан авсан байна. Мөн 2020 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэн MFC 1.0 эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийн төслийг эхлүүлж, шингэн хүнсний зах зээлд амжилттай нэвтэрсэн. Үйл ажиллагааг жигд тасралтгүй өргөжүүлэх зорилгоор ISO 14001:2015 байгаль орчны менежментийн тогтолцоо, FSSC 22000 хүнсний аюулгүй байдлын иж бүрэн тогтолцоо зэрэг олон улсын стандартын амжилттай хэрэгжүүлж эхлэн 2024 онд олон улсын SGS байгууллагаас баталгаажилтаа авсан.

## *1.2. ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ*

Үйлдвэрийн барилга нь 3 давхар бөгөөд 6500 м2 талбайтай, 1 давхарт үйлдвэрлэл, агуулахын хэсэг, 2 давхарт хуурай хүнсний үйлдвэр, 3-р давхарт оффис захиргаа, чанарын хяналтын лаборатори хэсэг байрладаг. Бэлэн бүтээгдэхүүний агуулах: Үйлдвэрлэлээс гарсан бүтээгдэхүүнийг хүлээн авах, түгээх зориулалттай, үйлдвэрийн барилгын зүүн урд талын 1, 2-р давхрыг бүхэлд нь хамарсан 800 м2 талбай бүхий GMP стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хадгалах агуулахтай.

## *1.3 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА*

### *1.3.1 ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР*

Шингэн хүнсний үйлдвэр нь 3 төрлийн найрлага бүхий 0.33 л, 0.5 л, 1.0 л-ээр савлагдсан "Экос" зөөлөн ус, Экос оргилуун ус, 4 төрлийн жимсний ундаа, 7 нэр төрлийн "Цэнэг" эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, Тайлагч шар тайлах бүтээгдэхүүн, "Vitos-shot" 3 төрлийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, увдист зэрэг шингэн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

Эмийн ургамалд агуулагддаг эрдэс бодис, амин дэмийн баялаг орц бүхий Витос брэндийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүд нь хүний биеийн дархлааг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйлдэлтэй. Тус брэнд нь эрдэмтэн, судлаачдын олон жилийн судалгаа шинжилгээ, шат дараалсан туршилтын үр дүнд бүтсэн юм. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тасралтгүй сайжруулсны үр дүнд хүний биед хурдан шингэх зохицолд нийцүүлэн шингэн бэлдмэл хэлбэрээр үйлдвэрлэж байна.



*Зураг 1. Үйлдвэрийн дотоод орчин, тоног төхөөрөмж*

### *1.3.2 ХУУРАЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР*

Хуурай хүнсний үйлдвэр нь нийт 1,950 м2 талбайтай. GMP стандарт хангасан үйлдвэр юм. Хуурай хүнсний үйлдвэр нь үрлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цай үйлдвэрлэл гэсэн 2 үндсэн хэсгээс бүрддэг.



*Зураг 2. Хуурай хүнсний үйлдвэрийн цех, бүтээгдэхүүний нэр төрөл*

## *1.4 ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ*

*Хүчин чадал:* “Монос Хүнс” ХК-ийн шингэн хүнсний үйлдвэрийн ус цэвэршүүлэх систем нь цагт 12000 л/цаг хүчин чадалтай бөгөөд үүнээс пэт савлагааны найрлагын шугам 12000 л/цаг, уутан болон хуруу шилэн савлагаатай бүтээгдэхүүний найрлагын шугам 2000 л/цаг байна. Харин савлагааны багтаамжаас хамааран савлагааны системийн хүчин чадал 3000-6000 сав/уут/цаг байна. Ургамал хандлах систем 1000 л/өдөр хүчин чадалтай.

*Хүснэгт 1. Үйлдвэрийн хүчин чадал*

| № | Төхөрөмжийн нэр | Хүчин чадал |
|---|---|---|
| *1* | Ус цэвэршүүлэх систем | 12000 л/ц |
| | Найрлагын систем | |
| *2* | Пэт савтай бүтээгдэхүүний найрлагын шугам | 12000 л/ц |
| *3* | Уутан болон хуруу шилэн савлагаатай бүтээгдэхүүний найрлагын шугам | 2000 л/ц |
| | Савлагааны систем | |
| *4* | Пэт халуун савлагааны шугам (500 мл багтаамжтай савлагаа) | 3000 сав/ц |
| *5* | Пэт хүйтэн савлагааны шугам (500 мл багтаамжтай савлагаа) | 6000 сав/ц |
| *6* | Уутан савлагааны төхөөрөмж (1000 мл багтаамжтай уутан савлагаа) | 64500 уут/ц |
| *7* | Хуруу шилэн савлагааны төхөөрөмж (20 мл багтаамжтай хуруу шилэн савлагаа) | 3000 шил/ц |
| *8* | Ургамал хандлах систем | 1000 өдөрт |

Үйлдвэр бүтээгдэхүүний савлагаа бэлдэх, үлээх төхөөрөмж, 0.33-1.0 л хэмжээтэй бүтээгдэхүүн савлах шугам, найрлага бэлдэх үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. *Тоног төхөөрөмж*: Бүтээгдэхүүний савлагаа бэлдэх, үлээх төхөөрөмж, 0.33л, 0,5л, 1.0 л хэмжээтэй бүтээгдэхүүн савлах шугам, найрлага бэлдэх үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. Ургамал хандлагч төхөөрөмжийн хүчин чадал 3000 шил/цаг, усны хэрэглээ 0.5 м3/ц. Пэт савлагаатай ус ундаа үйлдвэрлэгчийн хувьд хамгийн чухал хүчин зүйл нь сав байдаг. Пэт савны бэлдцийг БНХАУ-аас оруулж ирж, өөрийн үйлдвэрт суурилагдсан төхөөрөмжид үлээж, хэвэнд оруулна.

- ✓ Сав үлээх хошууны тоо: 6
- ✓ Хүчин чадал: 6000 сав/цаг (500мл багтаамжтай сав үлээх)
- ✓ Эзэлхүүн: 6000мм x 2000мм x 2300 мм

Тус тоног төхөөрөмж нь SMC, MAC, Omron, Mitsubishi, MCGS, Inovance, Schneider зэрэг үйлдвэрийн эд ангиудаар тоноглогдсон.
Савлах төхөөрөмж нь SEW, Mitsubishi, Weinview, Schneider, Omron, NSK, Airtac компаниудын эд ангиудаар тоноглогдсон,

- ✓ Хүчин чадал: 0-8000 сав/ц (500мл)
- ✓ Дүүргэх хурд: 140-150 мл/с
- ✓ Эзлэхүүн: 2400мм x 1850 мм x 2400мм
- ✓ Нийт жин: 4500 кг

Савлах төхөөрөмж нь SEW, Mitsubishi, Weinview, Schneider, Omron, NSK, Airtac компаниудын эд ангиудаар тоноглогдсон.

- ✓ Хүчин чадал: 0-3000 сав/ц (500мл)
- ✓ Дүүргэх температур: 85C
- ✓ Эзлэхүүн: 2400мм *x* 1850 мм x 2400мм
- ✓ Нийт жин: 3500 кг

Уутан савлагаа нь орчин үеийн эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүний трэнд савлагаа бөгөөд авч явахад, хэрэглэхэд хялбар, хэмжээ багатай байдаг онцлогтой аж.

- ✓ Хүчин чадал: 4500-5000 уут/ц
- ✓ Ажиллах даралт: 0,5-0,7 Mpa
- ✓ Цахилгаан: 50Hz 380v, 2.2 Kw
- ✓ Биет үзүүлэлт: 2500мм x 1580мм x 1950мм

*1.5 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ*

“Монос Хүнс” ХК нь эрүүл мэндийн хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, эко хүнсний олон улсын үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцож, гадны эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж, судалгаа шинжилгээ тогтмол хийдэг байна. Уг судалгаа шинжилгээнд үндэслэн хүнсний салбарын чиглэлийг биологийн өндөр идэвхт бүтээгдэхүүн тэргүүлнэ гэж үзэж бөгөөд шингэн болон хуурай хүнсний үйлдвэрлэлийн төслийн хүрээнд биологийн өндөр идэвхт бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлэн гадаа, дотоодын зах зээлд нийлүүлэн ажиллаж байна. Үүнд

1. Экос ус зөөлөн ус 0.33 л, 0.5 л, 1 л – 1 төрөл
2. Экос оргилуун хийжүүлсэн ус 0.5 л, 1 л - 1 төрөл
3. Экос эрдэс нөхөгч ус 0.5 л, 1 л - 1 төрөл
4. Тугал шахмал ааруул – 1 төрөл
5. Беррививт брэнд Ааруултай үрэл - 3 төрөл
6. Берривит брэнд Үзэмтэй үрэл - 6 төрөл
7. Берривит брэнд Витаминт-үрэл - 6 төрөл
8. Vitos брэнд /цэнэг брэнд/- 15 төрөл
9. Аами - Таами брэнд /Хаан жимс - жүүс/ - 4 төрөл
10. Увдист брэнд - 3 төрөл
11. Эко уусдаг цай - 9 төрөл
12. Энхжин цай - 8 төрөл
13. 100 наслаарай цай - 1 төрөл
14. Тайлагч- Хандгай /Шар тайлах бэлдмэл/ - 2 төрөл зэрэг болно.

*Хүснэгт 2. Шингэн хүнсний үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн*

| | | |
|---|---|---|
| Витос – Цэнэг Эрүүл мэндийн бэлдмэл | Цэнэг эрүүл мэндийн бэлдмэл нь анх импортын бүтээгдэхүүнийг орлох зорилгоор бүтээгдэж байсан бол эдүгээ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн 3 дахь шатандаа амжилттайгаар туршигдаж, баялаг орц, шинэчлэгдсэн савлагаа, өнгө төрхтэйгөөр хэрэглэгчдийн гар дээр очоод байна. |   |
| Витос-Шот эрүүл мэндийн бэлдмэл | Авсаархан савлагаатай, хэрэглэхэд хялбар шийдэлтэй Витос-Шотын гол онцлог нь хүний биед нэн шаардлагатай, бүтэн өдрийн амин дэмийн хэрэгцээг бүрэн хангах хүчирхэг үйлдэлтэйд оршдог. Бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэснээр дархлаа дэмжиж аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой юм. |   |
| *Vita 500 /Витамин С/* | Хүний биеийн дархлааг дэмждэг амин дэмүүдээс хамгийн хүчирхэг үйлдэлтэй нь Витамин С юм. Витамин С 500мг-ийг агуулсан тус бүтээгдэхүүнийг байгалийн зэрлэг жимсний охь, нэмэлт амин дэмээр баяжуулсан тул хүний дархлалын системийг гадны эсрэг биетээс бүрэн хамгаалж өгдөг. Мөн амны цангааг тайлна. |  |
| *Экос /Эрүүл амьдралын ус/.* Экос брэнд нь зөөлөн, оргилуун, эрдэс | Байгалийн хужраар зөөлрүүлсэн pH 8.5-тай шүлтлэг ус нь хүний биед шаардлагатай шингэн, эрдэс бодисыг нөхөж өгдөг. Ялангуяа цээж хорсох зовиуртай хүмүүс тогтмол хэрэглэснээр хүчил шүлтийн тэнцвэрт байдал хадгалагдах эерэг нөлөөтэй юм. |   |

| | | |
|---|---|---|
| нөхөгч гэсэн нийт 3 нэр төрлийн бүтээгдэхүүний н бүрдэлтэй. | Байгалийн хужраар зөөлрүүлж, хийжүүлсэн оргилуун ус нь таныг сэргээж, шинэлэг таатай мэдрэмжийг өгөх бөгөөд биед шаардагддаг шингэн эрдэс бодисыг нөхөх үйлчилгээтэй. Мөн амны цангаа тайлж, хоол боловсруулалтыг дэмжинэ. |  |
| | Харин Экос эрдэс нөхөгч усыг спортоор хичээллэдэг хүмүүс тогтмол хэрэглэснээр дасгал хөдөлгөөний үед хөлсөөр дамжин алдагдсан шингэн, магни, кали, кальци, натри, цайр,<br>төмөр зэрэг эрдэс бодисуудыг нөхөх давуу талтай. |  |
| Ачлалт эмийн ургамал, амин дэмт жимснүүдийн төгс хослол-увдист эрүүл мэндийн бэлдмэл | Монголын уламжлалт анагаах ухааны судар бичигт хүний биеийг хоргүйжүүлэх чадварыг нь шагшин тэмдэглэсэн гайхамшигт ургамлууд бол хунчир болон саримс юм.<br>Монос Хүнс ХК-ийн хамт олон эдгээр ургамлуудын хоорондын нийцэл, шүтэн барилдлагад үндэслэж Увдист эрүүл мэндийн бэлдмэлийг бүтээсэн бөгөөд дархлаа дэмжих, тамир сэргээх өндөр үр дүнтэй. Ялангуяа хортой нөхцөлд ажиллаж, амьдарч буй хүний биеийн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг дэмжих, эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлдэг. |  |
| Ноён шүүс жимсний ундаа | Ноён талх хүүхэлдэйн цуврал киноны Ноён шүүс байгалийн цэвэр жимсний ундаа нь хүүхэд бүрийн дуртай хэрэглээ болжээ. Энэхүү ундаа нь сахарын агууламж багатайгаас гадна ДЭМБ-ийн зөвлөмжид заасан эрүүл хүүхдийн хоногт авбал зохих витамин С-ийн тунг агуулдаг юм. Тус бүтээгдэхүүн нь Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудын дархлааг бүрэн дэмжиж, ханиад томуу тусахаас урьдчилан сэргийлдэг. |  |
| Тайлагч шар тайлах бүтээгдэхүүн | Согтууруулах ундаанаас үүдэлтэй хордлого буюу шар тайлах, шарталтаас сэргийлэх, элэх хамгаалах бүтээгдэхүүн |  |

*Хүснэгт 3. Хуурай хүнсний үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн*

| | | |
|---|---|---|
| *Энхжин эрүүл мэндийн цай* | Монголчууд эрт дээр үеэс эх орныхоо эрс тэс уур амьсгалд зохицон ургадаг эмийн ургамлуудын анагаах чадвар, амин чанарыг нь шинжин, өөрсдийн амьдрал ахуйдааргөнөөр хэрэглэж ирсэн билээ. Өвөг дээдсээс өвлөгдөж ирсэн энэхүү уламжлалыг орчин үеийн судалгаа шинжилгээ, онол арга зүйтэй хослуулан, эмийн ургамлуудын биологийн идэвхт нэгдлүүдийг нэгтгэсэн бүтээгдэхүүн бол Энхжин эрүүл мэндийн цувралацай юм. Тус цуврал нь нийт 8 нэр төрлийн бүтээгдэхүүнтэй. |  |
| *Гоолингоо тураах цай* | Энэхүү цайны найрлагад орсон ургамлууд нь бүдүүн гэдэсний ханыг цочроож, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулснаар ходоод гэдэсний ханын өнгөрийг цэвэрлэж, нарийн гэдсэнд хуримтлагдсан илүүдэл ялгадсыг гадагшлуулдаг юм. Ингэснээр хоолны шингэц сайжран, бодисын солилцоо тогтворждог. Улмаар биеийн өөхлөлт буурч, жин хасахаас гадна өтгөн хаталтыг багасгаж, цусан дахь холестерины хэмжээ бууруулах үйлдэлтэй. |  |

| | | |
|---|---|---|
| *100 наслаарай Монгол цай* | Эм судлалын хүрээлэн болон Монгол Улсын Их Сургуулийн эрдэмтдийн хамтарсан багийн 5 жилийн судалгааны дүнд бүтсэн энэхүү цайны найрлагад нарийн навчит хөвөн оройт, сөөгөн боролзгоно, алирсны навч зэрэг эмийн ургамлууд оржээ. Эдгээр эмийн ургамал нь антиоксиндат буюу биеийг хоргүйжүүлэх, хөгшрөлтийг саармагжуулах хүчтэй хариу үйлдэлтэй болох нь судалгаагаар нотлогдсон юм. Мөн зүрх судасны өвчлөл, хорт хавдар, чихрийн шижин, элэгний үрэвсэл, цусны даралт гэх мэт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй. |  |
| *TASTEA* | Найрлагандаа цагаан гаа, зөгийн бал, нимбэг, турмерик агуулсан энэхүү цай нь хүйтэн сэрүүний улиралд идэвхждэг ханиад томуу зэрэг улирлаас шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих үйлчилгээтэй. Тус цайны сайхан амт нь сэтгэл санааг сэргээх онцгой чадвартай юм. |  |
| *Бэррнвит үрэл* | Бэррнвит үрэл нь ааруултай, үзэмтэй, витаминт, тоглоомтой гэсэн 4 нэр төрлөөр үйлдвэрлэгддэг. Тус бүтээгдэхүүний найрлагад Монгол орны үржил шимт хөрсөнд ургасан аньс, нэрс, чацаргана жимсний шүүсийг ашигладаг тул дархлаа дэмжих давуу талтай. Ааруултай үрэл нь кальциар нэн баялаг тул хүүхдийн өсөлт хөгжилтөд эерэг нөлөөтэй. Мөн үзэмтэй үрэл, витаминт үрэл нь витамин С-ээр баялаг учир дархлааг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлдэг. |  |
| *Эко уусдаг цай* | Монголын цайны зах зээлд үйлдвэрлэгдсэн хамгийн анхны бөгөөд цорын ганц уусдаг цай бол Эко уусдаг цай юм. Тус цайг орчин цагийн дэвшилтэд технологийн тусламжтайгаар байгалийн зэрлэг жимсийг, ямар нэгэн хиймэл амт үнэр оруулагч бодисгүйгээр хар цайны хандaнд уусган бэлтгэдэг юм. |  |
| *Барагшун* | Барагшуныг уламжлалт анагаах ухаанд 3000 жилийн өмнөөс хэрэглэж ирсэн бөгөөд 400 гаруй өвчин эмгэгийг анагаах увьдистай. Мөн элдэв төрлийн урхагт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж ирсэн. Тус бүтээгдэхүүн нь эдгээр давуу талуудыг өөртөө шингээснээс гадна хэрэглэхэд хялбар болсноороо онцлог юм. |  |

## *1.6 ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ДОТООД ЛАБОРАТОРИ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ*

Лаборатори нь анх 2012 онд чанарын албаны дэргэдэх жижиг лаборатори болон үүсгэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа өргөжүүлэн тэлсээр 2022 онд MNS ISO/IEC 17025 стандартаар 2 жилийн хугацаагаар итгэмжлэлээ гардан авсан. Итгэмжлэл олгогдсон хугацаанд бид химийн шинжилгээний 5 үзүүлэлтээр итгэмжлэлийн хамрах хүрээг тэлж 2024 оны 9 сард давтан итгэмжлэлээ амжилттай хамгаалж дахин 4 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн итгэмжлэлийн гэрчилгээгээ сунгасан байна. Лаборатори нь боловсон хүчний хувьд хөдөлмөрийн гэрээтэй, орон тооны нийт 9 ажилтантай. Үүнд: лабораторийн эрхлэгч-1, ахлах химич-1, химич-3, лаборант-1, микробиологич-2, дээж авагч-1 ажилладаг. Лабораторийн ажилтнууд нь МУИС, ШУТИС-ийг химич, хими технологич, биохимич, химич, биотехнологич/микробиологич мэргэжлээр төгссөн, сорилтын салбарт 1-10 жил, тухайн албан тушаалд 1-6 жил ажииласан туршлагатай, гадны болон дотоодын урт, богино хугацааны сургалтад хамрагдсан байна.

Лаборатори нь давхардаагүй тоогоор нян судлал 13, хими 49, тухайлбал Экос усны үйлдвэрлэлийн явцад нийт хими 37, давхардсан тоогоор нян судлал 38 үзүүлэлтийг тодорхойлдог.

Лаборатори нь дотоод системийн хувьд ЛИМС программыг сонгон хэрэглэдэг бөгөөд анхны дээж бүртгэлээс эхлээд эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх хийгдэх бүхий л шинжилгээг цахим хэлбэрээр бүртгэлжүүлж цахим архив үүсгэн хадгалдаг.

Лаборатори нь хими болон нян судлалын 2 хэсгээс тоотох бөгөөд 2 лабораторийн нийт тоног төхөөрөмжийн газардуулагчийг шийдсэн. Бие даасан агааржуулалтын системтэй бөгөөд зөв урсгалыг бий. Ажлын тусгай хэсгүүдэд хальтардаггүй, усны хамгаалалттай, хагарал цуурал зураас үүсэхгүй, антибактериал чанарын хулдаас хулдаастай. Химийн бодисыг бүртгэлжүүлж хадгалан, түүний ашиглалт зарцуулалтын тайланг хөтөлж холбогдох ажилтанд хүлээлгэн өгдөг. Лабораториос гарах аюултай тусгай хог хаягдал/тэжээлт орчин, халдварлагдсан материал, химийн бодисын сав, хагарсан шил сав г.м/-ыг Элемент медикалтай хийсэн гэрээний дагуу хүлээлгэн өгч устгуулдаг.

Нян судлалын лаборатори

- Нийт 9 өрөө бүхий 89.3м$^2$ талбайд 10 ариутгалын UV гэрлийг суурьлуулж өгсөн
- Зориулалтаараа өөр өөр шинжилгээний 4 өрөө/ТЭМ, ББ шинжилгээний 2 өрөө, цэвэр өсгөврийн 1 өрөө, хөгц мөөгөнцрийн 1 өрөө/
- Бодис урвалж, жингийн өрөө
- Устгал, угаалга, ариутгалын тус тусын өрөөтэй
- Зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон/Микроскоп, автомат пипетка, термостат, хатаах шүүгээ, ламинар бокс, анаэростат, агаарын сорьц авагч, цэвэр өсгөвөр г.м/

Химийн лаборатори

- Нийт 72.2м$^2$ бүхий 5 өрөө бүхий лаборатори
- Багажит анализ-2, химийн бодисын өрөөг тусгаарлаж өгсөн
- Химийн шинжилгээний тус тусын хэсгийг шийдэж өгсөн
- Зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон/Аналитик жин, соронзон холигч, шатаах зуух, агаар сорогч хоолой, озонометр, mettler toledo-ph хэмжигч, бодисын шүүгээ, бодисын сеф, хаягдал бодисын тусгай тавиур, спектофотометр г.м/

ХАБЭА чиглэлээр 2 лаборатори тус бүр эмийн сан, галын хор, аюулгүйн хэрэгслээр тоноглогдсон. Осолын үед ашиглах нүд угаагч болон доошоо урсах трампийг шийдэж өгсөн. Мөн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл тухайлбал нүдний шил, нэг удаагийн масз, хошуувч, хорт утааны баг, хормогч, ханцуйвч гэх мэт хэрэгслээр бүрэн хангагдсан байна. Химийн бодис хадгалах өрөөтэй, өрөөнд бодис тусгаарлах шүүгээтэй, шүүгээ бүр химийн бодисын ууршилтыг гадагшлуулах тусгай хоолойтой.

Лаборатори нь үр дүнгийн үнэн бодит байдлыг хангах чиглэлээр

- ✓ ХАБУЛЛ ур чадварт жилд 2 удаа, ГСШТ ур чадварын хөтөлбөрт жилд 1 удаа хамрагддаг бөгөөд амжилттай хамгаалсан.

- ✓ Лабораторийн хоорондын харьцуулалтыг Монос Фарм ХХК, Гацуурт ХХК, НЭМҮТ-тай хамтран гэрээтэй дагуу хийдэг.
- ✓ Шинжээч хоорондын харьцуулалтыг улирал бүр тогтмол хийж шинжилгээ бүрийг баталгаажуулдаг.
- ✓ Шинжилгээний баталгаажилтыг хангах зорилгоор аргын баталгаажилтыг хагас жил тутам хийж гүйцэтгэдэг.

## *1.7 ДЭД БҮТЭЦ*

*Цахилгаан хангамж:* Улаанбаатар хотын цахилгаан түгээх төвлөрсөн сүлжээнд холбогдсон байна. Монос группын үйлдвэрийн цогцолбор байрлах 33966 м2 талбай бүхий газрын эзэмшигч “Монос Хүнс” ХК бөгөөд “Цахилгаан эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээ”-г “ДЦС-3” ТӨХК-тай байгуулсан байна.

*Дулаан хангамж:* Үйлдвэрийн барилга байгууламж нь бүхэлдээ Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон. Ус цэвэршүүлэх төхөөрөмжөөс гарах хатуулаг ихтэй хаягдал усыг 10 тн багтаамжтай нөөцийн саванд хуримтлуулж, угаалтаас гарах хаягдал усны шингэрүүлэлт, ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээнд ахуйн зориулалтаар дахин ашиглаж байна.

*Ариутгах татуурга:* Үйлдвэрийн барилгаас гарах хаягдал ус нь мөн УСУГ-тай байгуулсан “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ"-ний дагуу төвлөрсөн сүлжээнд нийлүүлэгддэг. Үүнд ажилчдын ахуйн хэрэглээ, ажлын байрны цэвэрлэгээ болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээний хаягдал ус бүгд хамаарна.

*Хаягдал ус /саарал ус/ ашиглалт:* Тус компани нь усны зохистой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн төлөвлөлтийг оновчтой болгож, үйл ажиллагаанаас гарч буй илүүдэл (саарал) усыг дотоод хэрэгцээндээ бүрэн ашигладаг. Үйлдвэрлэлийн байранд 24 тонны багтаамжтай саарал ус нөөцлөх системийг суурилуулсан бөгөөд уг нөөцөлсөн усыг дотоодын цэвэрлэгээ үйлчилгээ, ариун цэврийн өрөөний зайлуулалт болон гаднах ногоон байгууламжийн усалгаанд зориулалтын дагуу ашиглаж байна. Мөн 2025 оны 11 сард Баянгол цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-тай 3-н жилийн хугацаатайгаар саарал усаа нийлүүлэх, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах, зам талбайн цэвэрлэгээнд ашиглахаар санамж бичиг байгуулан ажиллаж байна.

## *1.8 ХОГ ХАЯГДАЛ*

*Ахуйн хаягдал:* Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлыг түр цэгт хуримтлуулан, Баянгол дүүргийн тохижилт үйлчилгээ хариуцсан “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу тээвэрлэгч байгууллагад нийлүүлж байна. Хог хаягдал зайлуулах үйлчилгээний хураамжийн хэмжээг Баянгол дүүргийн ИТХ-ын 7/04 тоот тогтоолд заасан тарифаар тооцон, үйлчилгээний хөлсийг төлдөг.

Аюултай хог хаягдал:

*Химийн бодисын сав баглаа боодол:* Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23 өдрийн 54/А/136/А/215 тоот хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 6.4-т зааснаар цэвэрлээгүй химийн бодисын сав баглаа боодлыг аюултай хог хаягдал гэж үзнэ. Мөн БОАЖ-ын сайдын 2018 оны 11 сарын 13 өдрийн А-429/257 тоот тушаалын хавсралтаар батлагдсан үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтад "Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол” багтаж байна. Иймд “Монос Хүнс" ХК нь Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5-т “Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх" гэж заасны дагуу химийн бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагад буюу гэрээний дагуу нийлүүлэх шаардлагатай. Тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээнд ашиглаж буй химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг одоогоор өөрийн үйлдвэрт тусгай агуулахад бүртгэлжүүлэн хадгалдаг. Химийн бодисын сав баглаа боодлыг нийлүүлэгч “Жи Эф Ай” ХХК-тай байгуулсан худалдах-худалдах авах гэрээнд зааснаар импортлогч байгууллагад буцаан нийлүүлэхээр төлөвлөсөн. Химийн бодисын сав баглаа боодол нь 20, 23, 25, 30 болон 250 кг-ийн багтаамжтай хуванцар савнууд байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээний бодисуудын хуванцар сав нь жилд 170 орчим ширхэг гарч байгаагаас 250 кг багтаамжтай сав 24 ш, 20-30 кг багтаамжтай хуванцар сав 140 гаруй тоогоор гарахаар байна.

*Микробиологийн хаягдал:* Төсөл хэрэгжүүлэгч нь дотоод хяналтын лабораториос гарах био хаягдлыг “Элемент медикал” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 14 хоногт 1 удаа устгуулдаг. Хаягдал хуримтлуулах зориулалтын “био хаягдал” бүхий тэмдэглээтэй, шар өнгийн, автоклавын температурт тэсвэртэй уутыг Монбиофарм ХХК-иас худалдан авч ашигладаг.

Шингэн хаягдал:

*Ахуйн шингэн хаягдал:* Ажилчдын ахуйн хэрэглээ, ажлын байрны угаалга цэвэрлэгээнээс гарах шингэн хаягдлыг ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлдэг.

*Холимог уусмалын хаягдал:* Химийн лабораторийн шинжилгээнээс хоногт 0.2-0.3 л, жилд 53.8 л орчим химийн бодис агуулсан холимог уусмал, мөн сав баглаа боодлыг угааж цэвэрлэсэн хаягдал ус гарна. Үүнийг байгалийн шохой (CaO)-оор саармагжуулан, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг.

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээний шингэн хаягдал. “Монос Хүнс” ХК-ийн шингэн хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээний хаягдал ус гарч, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэгддэг. Ариутгах татуургын сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн бохир ус нь Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид хүрдэг. Тоног төхөөрөмжийн CIP (тоног төхөөрөмж, шугам хоолойг салгалгүйгээр гадаргууг шууд цэвэрлэх) цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа хийдэг ба хүчил, шүлтийн уусмалыг шингэрүүлэн (хүчлийн уусмал 1.0-1.5%, шүлтийн уусмал 1.5-2.0%) хэрэглэдэг. Энэхүү угаалгын уусмалыг 2 тн-ын багтаамжтай 2 ширхэг танканд хуримтлуулж, тодорхой давтамжтайгаар дахин ашиглаж, сард 1 удаа 0.5% хүртэл шингэрүүлэн, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг. Цэвэрлэгээний хаягдал усны хэмжээ 48 тн/жил орчим байна.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

## *2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ*

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Монос Хүнс” ХК-ийн “Шингэн болон хуурай хүнсний үйлдвэрийн төсөл”-ийн 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 4 . 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө | мян.төг | 6,500,000 | Сар бүр |
| 2 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | мян.төг | 3,500,000 | Сар бүр |
| 3 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | мян.төг | 3,000,000 | Сар бүр |
| 4 | Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | мян.төг | 2,800,000 | Улирал бүр |
| 5 | Байгаль орчны аудит | мян.төг | - | |
| 6 | Тэрбум мод үндэсний хөтөлбөр | мян.төг | 23,500,000 | Хавар, Намар |
| 7 | Булгийн эх хашаалах | мян.төг | 30,000,000 | Хагас жилд 1 удаа |
| 2026 оны нийт зардал | | | 69,300,000 | |

2026 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд:

- ✓ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах;
- ✓ Эх үүсвэр дээрх хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх;
- ✓ Үйлдвэрийн хаягдал бохир усны чанарт хяналт тавьж, стандартын шаардлага хангасан хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх;

## 2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 5. 2026 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Гол болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн үнэ (мян.төг) | Баримтлах стандарт |
|---|---|---|---|---|---|
| | | Нэг. Цаг уур, уур амьсгалаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | |
| 1 | Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалвал хэт хөрсноос талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөх, өндөр температурт хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах | Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбооны механик бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисыг долоо хоногт 1 удаа шалгаж хяналтыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх | Төслийн талбайд | 1,200,000 | NS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах.<br>Ерөнхий шаардлага Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах |
| 2 | Шингэн төлөвтэй бодисууд дулааны нөлөөгөөр тэлэх, улмаар хальж асгарах | Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай боловч тогтмол инженер техникийн үзлэг, хяналт хийх | Төслийн талбайд | 1,500,000 | MNS 6458:2014 Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах, ХАЛМ, MSDS |
| | | Хоёр. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | |
| 3 | Орчны агаарт бохирдуулагч бодис ялгарах | Үйлдвэрийн дотоод болон гадаах орчны агаарын чанарын мониторингийг тогтмол тасралтгүй хийх. Ингэхдээ нийт тоосонцор, азотын давхар ислийн хэмжээг агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага болох MNS 4585:2016 стандартын сөрөг нөлөөллийн хүлцэх агууламжийн дагуу хянана. | Үйлдвэрийн талбай | БО хяналт шинжилгээ ний хөтөлбөрт багтсан. | MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага<br>MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт<br>MNS 4990:2000. Ажлын |

| № | Гол болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн үнэ (мян.төг) | Баримтлах стандарт |
|---|---|---|---|---|---|
| 4 | Машин механизм, тоног төхөөрөмжүүдийн хөдөлгөөн, дотоод шаталтат хөдөлгүүрийн ажиллагаанаас агаар бохирдуулагчид ялгарах | Авто тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх | Машин техник тээврийн хэрэгслүүд | 1,500,000 | байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага<br>MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага<br>MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга |
| 5 | Химийн бодис хадгалах горим алдагдан химийн бодис ууршиж, агаарт дэгдэх. | Химийн бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны зохистой горимыг чанд баримтлах. | Үйлдвэрийн талбай, химийн бодистой ажиллах орчин | ХАБЭА-гийн зардалд тусгагдсан. | |
| 6 | | Химийн бодисыг гал авалцах эх үүсвэр, шатамхай материалуудаас тусад нь хадгал. | | | |
| | | Гурав. Гадаргын болон газрын доорх ус | | | |
